



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Нууцын ажлыг сайжруулах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа агентлаг, байгууллагын дарга, захирал, албан тушаалтанд үүрэг болгосугай.

1.1. Байгууллагадаа Төрийн болон албаны нууцын тухай хууль сурталчлах ажлыг зохион байгуулах;

1.2. Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараах журмын холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. Үүнд:

1.2.а/ Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам,

1.2.б/ Төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт шалгалт хийх журам

1.2.в/ Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журам,

1.2.г/ Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам,

1.2.д/ Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам.

1.3. Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан нууцын зэрэглэлийн тэмдэглэгээний дардасуудыг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулж, албан хэрэгцээнд ашиглах;

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Төрийн нууцтай танилцах албан тушаалтны жагсаалт гарган батлах;

3. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжилтийг хангаж ажиллах;

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ